



# Жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ

# Зорилтууд

1. Жендэрийн дүн шинжилгээ хийх ойлголтыг нэмэгдүүлэх :
  - Зорилго ба зарчмууд
  - Үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд
2. Жендэрийн дүн шинжилгээг ашиглах боломж

# Гол үзэл баримтлал

## **Хүйс:**

Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын биологийн ялгаа;

- *Өөрчлөгдөх боломжгүй ба түгээмэл*

## **Жендэр:**

Эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгмээс тогтоосон эрх үүрэг, хариуцлага, онцлог ялгаанууд; хүйсийн байдалд суурилсан зохистой зан үйл, хандлага, үйл ажиллагаа.

- *Гэр бүл, сургууль, шашны институт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр заасан / сурсан*
- *Цагийн эрхээр, мөн соёл хоорондын болон дотоодод нь гарсан өөрчлөлтүүд*

# Гол үзэл баримтлал

## Жендэрийн тэгш байдал:

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд эрхээ хамгаалахын тулд нийгэмд ижил тэгш байр суурьтай.

- *Энэ бол тэд яг адилхан биш боловч тэдний ижил төстэй байдал , ялгаатай талыг хүлээн зөвшөөрч, тэд адил тэгш үнэлэгддэг гэсэн үг юм.*

# Гол үзэл баримтлал

## Жендэрийн ялгаварлал :

Хүмүүст адил тэгш биш, шударга бусаар хандах явдал нь тэдний ур чадвар, авьяас билиг, чадамжаас илүүтэй зөвхөн хүйсийн байдал дээр тулгуурладаг байна.

Жишээ нь :

- Нийгмээс гадуурхах
- Шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжгүй байлгах
- Үйлчилгээ болон нөөцийн хүртээмжийг хязгаарлах



- *Хүмүүстэй адил тэгш харьцах нь магадгүй өөр өөр хүмүүст ижилхэн үр дүн өгдөггүй байж болно.*
- *"Тиймээс, адил тэгш харьцаа гэдэг нь "ижилхэн" харьцаа гэсэн үг биш.*

# Жендэрийн оролцоотой дүн шинжилгээ гэж юу вэ?

Энэ бол эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, аль эсвэл охид, хөвгүүдийн туршлага юугаараа ялгаатай болохыг судалж тогтоох үйл явц юм.

Бодлого гарагчид болон төсөл хөтөлбөр боловсруулагч нар түүнийг дараах зорилгоор ашигладаг. Үүнд :

- ✧ *эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд тулгараад буй янз бүрийн саад бэрхшээл, хязгаарлалтуудыг судалж тодорхойлох;*
- ✧ *Санал санаачилгаас адил тэнцүү ашиг хүртэх нөхцлийг бүрдүүлэх.*



# Гол зарчмууд

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нь бодлого болон хөтөлбөрийн үр дүнд бий болсон нөөц боломж, ашгаас адил тэгш хүртэх эрхтэй.

Бодлого, хөтөлбөрүүд нь дундыг баримталсан шинжтэй биш байх ёстой.

- *Санаатай ч, санаандгүй байдлаар ч өөр өөр хүмүүс, эсвэл өөр хэсэг бүлэг хүмүүсийн хувьд нэгэнд нь ашигтай байхад нөгөөд нь хортой, эсвэл тэр хоёрын аль нь ч биш байх тохиолдол байдаг.*

**Дүрэм № 1**

**Хор хөнөөлгүй байх**

**Дүрэм № 2**

**Зөв сайн зүйл  
хийх**



# Оролцуулах шинжилгээ : Богино хугацааны зорилго

*Жендэрийн ялгаа зөрүүг тодорхойлох :*

- Нөөцөөс хүртэх, түүнд хяналт тавих талаар эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх, оролцоонд байгаа ялгаатай байдал
- Хаана нэг хүйс нь нөгөөгөөсөө илүү эрх эдэлж, ашиг хүртэж байна вэ?



# Жендэрийн оролцоотой дүн шинжилгээний гол бүрэлдэхүүн хэсгүүд

Жендэрийн ялгаатай байдлын талаас судалж тогтоох, шинжлэх, ойлгох

1. Үүрэг ба хариуцлага
2. Нөөц / хөрөнгөөс хүртэх, түүнд хяналт тавих
3. Нийгэм, эдийн засаг болон орчны хүчин зүйлс (дээрх бүгдэд нөлөөтэй)

# Үүрэг ба хариуцлага

*Эмэгтэйчүүд, эрчүүдэд тэдний хүйсийн ялгаатай байдлаас шалтгаалан ялгавартай чиг үүрэг, үүрэг даалгавар, хариуцлага ногдуулах:*

## **Нөхөн үржихүйн үүрэг**

- Хоол бэлтгэх
- Хүүхэд асрах
- Өвчтөн болон өндөр настныг халамжлах
- Цэвэрлэгээ, угаалга, гэрийн ажил хийх

## **Бүтээмжийн үүрэг**

- Албан ёсны ажил эрхлэлт
- Хувиараа ажил эрхлэх

## **Олон нийтийн үүрэг**

- Сайн дурын/нийгмийн ажил
- Соёлын үйл ажиллагаа
- Засвар үйлчилгээ (зам, худаг ус гэх мэт)
- Харуул хамгаалалт-түүнтэй төстэй ажил

# Нөөцөөс хүртэх, түүнд тавих хяналт

## **Нөөцүүд:**

- Өрхийн орлого, газар, зээл, хөдөлмөр эрхлэлт
- Боловсрол, улс төрийн төлөөлөл, мэдээлэл
- Цаг хугацаа

**Хүртэх** : Тодорхой төрлийн нөөцийг ашиглах, ашиг шимийг хүртэх чадамж

**Хяналт**: Нөөцийг хэн ашиглах, эзэмших (газар худалдах /түрээслэх) талаар шийдвэр гаргах чадамж.

- Өрх гэр, олон нийт болон Засгийн Газрын түвшинд

# Нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хүчин зүйлс

Хүмүүсийн амьдралын өргөн хүрээ

Жишээнүүд:

- Соёл
- Нийгмийн байдал
- Физик орчин
- Боловсролын тогтолцоо, улс төр
- Нийгмийн дэмжлэгийн сүлжээ
- Генетик
- Хувь хүний физиологийн шинж чанар

# Урт хугацааны зорилго

Санал санаачилгуудаас эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш ашиг тус хүртэх

**Тэгш боломжоор хангах:** Эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн амьдралын бүхий л хүрээнд эрчүүд, эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн, тэгш оролцуулах боломжийг бүрдүүлэх.

**Нөхцлийг сайжруулах:** Практик хэрэгцээ: эрчүүд, эмэгтэйчүүдийн амьдралын материаллаг байдал

➤ Хоол хүнс, орон байр, бэлэн мөнгө, орлого гэх мэт.

**Байр суурийг сайжруулах :** Нийгэм дэх эдийн засаг, нийгмийн байдал

➤ Цалин хөлс, ажил эрхлэх боломж, өмчлөл; улс төрийн үйл явц дахь төлөөлөл гэх мэт.

# Урт хугацааны зорилго

**Эрх мэдэлжүүлэх:** Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрсдийнхөө амьдралыг хянадаг: өөрсдөө асуудлаа тодорхойлдог байх

- Зөвхөн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд л өөр өөрсдийн нэрийн өмнөөс ярьж өөрсдөө сонголтоо хийх эрх мэдлийг өөртөө бий болгож чадна.
- Байгууллагууд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, өөртөө итгэх итгэл, ур чадварыг дээшлүүлэх, бие даасан байдлыг хөгжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлж чадна.

# Яаж

***Тэгш байдлыг бий болгох:*** Нөөц баялаг, ашиг тусыг тэгш хүртэх боломжийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд олгох шударга үйл явц.

- Эмэгтэй, эрэгтэйчүүдэд гарааны ижил төстэй нөхцлийг бий болгох үүднээс түүхэн болон нийгмийн сул талуудыг тэгшитгэх арга хэмжээ авах хэрэгтэй байж болно.
- Энэ бол эрх мэдэл, ашиг тус, үүрэг хариуцлага, боломжийн хувьд тэгш байдлийг бий болгох үүднээс адил тэгш, эсвэл өөр боловч адил тэгш хандлагуудыг ашиглана гэсэн үг юм.



# Яаж

**Системчилсэн Нэгдсэн Төлөөлөл** : Бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг татан оролцуулах арга хэмжээ авах.

**Татан оролцуулах орон зай** : Янз бүрийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрийгөө сонсож байгааг мэдэрч, утга учиртай хувь нэмэр оруулж чадах орон зайг бий болго.

➤ хөтөлбөр /бодлого  
боловсруулах бүх шатанд



# Хураангуй

1. Үйл явцдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг олон төрлийн бүлгүүдийг оролцуул
2. Санал санаачилгын зорилгод холбогдолтой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн туршлагын ялгааг олж харах
3. Ялгаа үүсгэж буй саад бэрхшээлийг тодорхойлох
4. Саад тотгор/ ялгааг арилгах арга хэмжээ авах
5. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн янз бүрийн бүлгийн оролцоог хангах замаар урт хугацааны зорилгодоо хүрэхэд гарч буй ахиц дэвшлийг хянах, үнэлж дүнэх

